

ОХУ-ЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

Г.ӨНӨРЖАРГАЛ

ҮАБЗ-ийн дэргэдэх

Стратеги судалгааны хүрээлэнгийн

Олон улсын аюулгүй байдал судалгааны

төвийн шинжээч

Энэхүү өгүүлэлд ОХУ-ын стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийн нэг болох шинэчлэн батлагдсан Үндэсний аюулгүй байдлын стратегид тусгагдсан ОХУ-ын гадаад, дотоод бодлого, батлан хамгаалах, эдийн засагийн аюулгүй байдлын талаар дэвшүүлсэн шинэ зорилт зэргийг өмнө батлагдсан буюу 2015 оны үндэсний аюулгүй байдлын стратегитай харьцуулан харуулахыг зорив.

Оршил

Оросын Холбооны Улсын Үндэсний аюулгүй байдлын стратеги нь Холбооны хуулиар зохицуулагддаг¹ стратеги төлөвлөлтийн суурь баримт бичгүүдийн нэг юм.

ОХУ-ын стратеги төлөвлөлтийн тухай 2014 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн Холбооны хуулийн №172-ын 11-ийн 1,2 дугаар хэсэгт заасан стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийг ач холбогдлоор нь авч үзвэл,

- ОХУ-ын ерөнхийлөгчийн Холбооны Зөвлөлд хийх жил бүрийн илгээлт;
- ОХУ-ын нийгэм эдийн засгийн хөгжлийн стратеги;
- ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын стратеги;
- ОХУ-ын ШУ, технологийн хөгжлийн стратеги зэргээс гадна, тус улсын ҮАБ-ыг хангахад чиглэсэн бодлогын хийгээд бусад салбарын номлол зэрэг багтана².

Стратеги төлөвлөлтийн бичиг баримтыг ерөнхийд нь засаглалын түвшнээс хамаарч холбооны, бүс нутгийн, орон нутгийн өөрөө удирдах түвшний хэмээн ангилж болох бол зорилго зорилтын үүднээс зорилго тодорхойлох, урьдчилан таамаглах, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах зэрэг 4 шатлан ангилж үзнэ.

Үүнээс үзэхэд ОХУ-ын ҮАБ-ын стратеги нь тус улсын стратеги төлөвлөлтийн суурь баримт бичгүүдийн нэг болохын зэрэгцээ үндэсний ашиг сонирхол, стратегийн тэргүүлэх чиглэл, үндэсний аюулгүй байдлыг хангах хийгээд түүнийг хэрэгжүүлэх зорилго, зорилтыг тусгасан, тогтвортой хөгжлийн арга замыг

1 Федеральный закон от 28.06.2014 г. № 172-ФЗ О стратегическом планировании в Российской Федерации <http://www.kremlin.ru/acts/bank/38630>

2 О стратегическом планировании в Российской Федерации : фе-дер. закон от 28 июня 2014 г. № 172-ФЗ // Рос. газ. 2014. 3 июля. Части 1, 2 ст. 11.

тодорхойлсон бичиг баримт юм. Тус баримт бичгийг дурдсан хуулийн дагуу 6 жилд нэг удаа шинэчлэн баталдаг бөгөөд энэ удаад 2021 оны 5 дугаар сард ҮАБЗ-өөр, 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр ерөнхийлөгч В.Путины № 400 тоот зарлиг³ гарснаар улс орны бодлогын ойрын ирээдүйн чиглэл, хандлагаа тодорхойлов.

Нэг. Баримт бичгийн агуулга

Энэ удаад шинэчлэн баталсан ҮАБ-ын стратеги нь 44 хуудас, 5 бүлэгтэй байна. Тус баримт бичгийн 2015 оны хувилбарын Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай 4 дүгээр бүлэгт *иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эрүүлийг хамгаалах* зэрэг дэд бүлгүүд байсан бол шинэ хувилбарт хасагдаж *мэдээллийн аюулгүй байдал, түүх соёлын дурсгал болон ард түмний уламжлалт оюуны өвийг хамгаалах* зэрэг дэд бүлгүүд шинээр болон шинэчлэгдэн оржээ. Мөн өмнөх баримт бичигт “эдийн засгийн өсөлт” нь үндэсний аюулгүй байдлыг хангах зорилт болж байсан бол шинэчлэн найруулсан хувилбарт “эдийн засгийн аюулгүй байдал” болж өөрчлөгдсөн байна. Дээр дурдсан иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эрүүлийг хамгаалах зэрэг дэд бүлгүүдийг шинэ стратегид “иргэдийн хамгаалал, хүний чадамжийг хөгжүүлэх” бүлэгт багтан Оросын стратегийн тэргүүлэх чиглэлийн тэргүүн эгнээнд орсон байна. Энэ талаар стратегийн баримт бичиг батлагдахаас өмнө буюу 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Холбооны Зөвлөлд хийсэн илгээлтдээ ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин “Оросын олон улсын тавцанд явуулж буй бодлого бол олон улсын энхтайван, тогтвортой байдлыг хангах нь юун түрүүнд ард иргэдийнхээ сайн сайхны төлөө, улс орны тогтвортой хөгжлийн төлөө юм⁴” хэмээн дурдаж байв.

Шинэчлэн баталсан стратегийн баримт бичгийг боловсруулагчдын зүгээс ямарваа эрс өөрчлөлтийг тусгаагүй, харин цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг өмнө хүрсэн үр дүнд түшиглэн төлөвлөсөн агуулгатай байна. Үүнийг баримт бичгүүдийн ерөнхий зүйлд хэрхэн тусгасныг доор харуулав.

2015 оны стратегийн ерөнхий зүйлийн	2021 оны стратегийн ерөнхий зүйлийн
3-р зүйлд: Тус стратеги нь ОХУ-ын үндэсний стратегийн тэргүүлэх чиглэл хийгээд үндэсний ашиг сонирхолыг хангахын тулд гадаад болон дотоод тааламжтай нөхцөл байдлыг бий болгохын тулд иргэний нийгэм, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, бүс нутгийн төрийн эрх барих байгууллага болон төрийн эрх барих холбооны байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэхэд чиглэгдсэн болно.	1-р зүйлд: ОХУ-ын зүгээс хэрэгжүүлж ирсэн батлан хамгаалах, дотоод эв нэгдэл, улс төрийн тогтвортой байдал, эдийн засаг болон үйлдвэрлэлийн шинэтгэл нь бие даасан гадаад, дотоод бодлого хэрэгжүүлэх, гадны дарамт шахалтыг үр дүнтэй сөрөн зогсох бүрэн эрхэт Орос Улс болгон бэхжүүлэв. ... Хүчирхэг гүрэн хийгээд баялагтай иргэний нэгдэл л гагцхүү Орос оронд хөгжил цэцэглэлт, шударга нийгмийг цогцлооно...

3 УКАЗ ПРЕЗИДЕНТА РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ <http://static.kremlin.ru/media/events/files/ru/QZw6hSk5z9gWq0plD1ZzmR5cER0g5tZC.pdf>

4 Послание Президента Федеральному Собранию <http://www.kremlin.ru/events/president/transcripts/messages/65418>

Оросын Холбооны Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Патрушев өмнөх баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэхдээ “... цэрэг дайны аюул заналаас найдвартай хамгаалагдсан бөгөөд нийгмийн болон улсын аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын бүрэн эрхт байдлыг хангахтай холбоотой зарим зорилтуудыг зохих түвшинд хэрэгжүүлж байгаа. Мөн террорист халдлагын идэвхжлийн түвшин буурсан үзүүлэлттэй байгаагаас гадна, Оросын эдийн засаг гадны хориг арга хэмжээ, дарамт шахалтыг сөрөн зогсох чадамжтай, тогтвортой гэдгээ батлан харууллаа⁵” хэмээн тэмдэглэв.

Хоёр. Үндэсний ашиг сонирхол, стратегийн үндэсний тэргүүлэх чиглэл

Стратегийн гуравдугаар бүлэгт ОХУ-ын үндэсний ашиг сонирхол болон үндэсний стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тусгасан байна. Үүнд улс орны дотоод хийгээд олон улс дахь үндэсний ашиг сонирхыг хэрхэн тодорхойлсныг өмнөх буюу 2015 онд батлагдсан баримт бичгийн заалттай харьцуулан авч үзье.

Хүснэгт 1. 2015 болон 2021 онд батлагдсан ҮАБ-ын стратегид тусгагдсан стратегийн үндэсний тэргүүлэх чиглэлүүд

	2015 оны ҮАБ стратеги	2021 оны ҮАБ стратеги
1	Батлан хамгаалах	Оросын ард түмнийг хамгаалах, хүний чадамжийг хөгжүүлэх
2	Улсын болон нийгмийн аюулгүй байдал	Батлан хамгаалах
3	Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах	Улсын болон нийгмийн аюулгүй байдал
4	Эдийн засгийн өсөлт	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах
5	Шинжлэх ухаан, технологи, боловсрол	Эдийн засгийн аюулгүй байдал
6	Эрүүлийг хамгаалах	Шинжлэх ухаан, технологийн хөгжил
7	Соёл	Экологийн аюулгүй байдал болон байгалийн баялгийг зохиостой хэрэглэх
8	Амьд байгалийн экологи болон байгалийн баялгийг зүй зохиостой ашиглах	Түүх соёлын дурсгал болон ард түмний уламжлалт оюуны өвийг хамгаалах
9	Стратегийн тогтвортой байдал болон ижил тэгш стратегийн түншлэл	Стратегийн тогтвортой байдал болон харилцан ашигтай олон улсын хамтын ажиллагаа

Эх сурвалж: Кремль болон Засгийн газрын хууль эрх зүйн баримт бичгийн порталаас боловсруулав.

5 Патрушев объяснил, зачем нужна новая стратегия нацбезопасности <https://ria.ru/20210531/strategiya-1734977111.html>

Стратегийн өмнөх найруулгад “эдийн засгийн өсөлт” зэрэг үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тэргүүлэх чиглэлийг шинэчилсэн найруулгад “эдийн засгийн аюулгүй байдал” хэмээн өөрчлөгдсөн байна. Өөр нэг чухал зүйл бол мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний тэргүүлэх чиглэлд оруулсан явдал юм. Тус тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд мэдээллийн чухал дэд бүтцийн байнгын ажиллагааг хангах, Оросын нийгмийг террорист, хэт даврагч байгууллагууд, гадаадын тусгай алба, суртал ухуулгын байгууллагуудын хор хөнөөлтэй мэдээллийн нөлөөллөөс хамгаалах зорилготой хэмээн үзэж байна. Бусад шинэлэг заалтын тухайд гэвэл Орос улс хиймэл оюун ухаанд шилжих, нүүрстөрөгчийн хий багатай технологид суурилсан үндэсний эдийн засгийн тогтолцоог хөгжүүлэх гэх мэт урьд өмнө тооцогдоогүй чиглэлийн талаар стратегид дурдсан болохыг тэмдэглэж болно.

*Хүснэгт 2. Оросын үндэсний ашиг сонирхол
(2015 болон 2021 онд батлагдсан ҮАБ-ын стратеги)*

	2021 оны стратегид	2015 оны стратегид
1	Оросын ард түмнийг хамгаалах, хүний чадамжийг хөгжүүлэх, ард иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх	Улс орны баглан хамгаалах салбарыг бэхжүүлэх, ОХУ-ын үндсэн хуулийн тогтолцоо, бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах
2	ОХУ-ын үндсэн хуулийн тогтолцоо, бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, улс орны баглан хамгаалах салбарыг бэхжүүлэх	Үндэсний эв нэгдэл, улс төр, нийгмийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, ардчилсан институцийг хөгжүүлэх, төр, иргэний нийгмийн харилцан үйлчлэлийн механизмыг боловсронгуй болгох
3	Улс оронд иргэний энх тайван, эв нэгдлийг сахин хамгаалах, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, авлигыг устгах, иргэд, өмчийн бүх хэлбэрийг хууль бус халдлагаас хамгаалах, төр, иргэний нийгмийн харилцан үйлчлэлийн механизмыг хөгжүүлэх	Амьдралын чанарыг сайжруулах, хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, улс орны хүн ам зүйн тогтвортой хөгжлийг хангах
4	Аюулгүй мэдээллийн орон зайг хөгжүүлэх, Оросын нийгмийг хор хөнөөлтэй мэдээлэл, сэтгэлзүйн нөлөөллөөс хамгаалах	Оросын уламжлалт оюун санаа, ёс суртахууны үнэт зүйлс, соёлыг хадгалан хөгжүүлэх
5	Оросын эдийн засгийг шинэ технологийн үндсэн дээр тогтвортой хөгжүүлэх	Үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
6	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	Үйл ажиллагаа нь олон төвт ертөнцөд стратегийн тогтвортой байдал, харилцан ашигтай түншлэлийг хадгалахад чиглэгдсэн ОХУ-ын хувьд дэлхийн тэргүүлэх гүрнүүдийн нэг статусыг бэхжүүлэх.

	2021 оны стратегид	2015 оны стратегид
7	Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлсийг бэхжүүлэх, Оросын ард түмний соёл, түүхийн өвийг хадгалах	
8	Стратегийн тогтвортой байдлыг хадгалах, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, олон улсын харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх	

Эх сурвалж: Кремль болон Засгийн газрын хууль эрх зүйн баримт бичгийн порталаас боловсруулав.

Харьцуулан буй баримт бичгүүдэд өнөө цагийн Оросын үндэсний ашиг сонирхлыг ач холбогдлын хувьд зарим зүйл заалтын байрыг өөрчлөгдсөнийг харж болно. Тухайлбал, шинэчлэн батлагдсан стратегид ард иргэдээ хамгаалах, хүний хөгжил, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх заалт тэргүүн эгнээнд тавигдсан бол өмнөх стратегид улсын батлан хамгаалах салбар, бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах заалтыг тэргүүн эгнээнд тавьж байв.

Энэ нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлын тэргүүнд гадны гэхээсээ илүү дотоод хүчин зүйл буюу хүн ам зүйн асуудалд анхаарал хандуулж байна. Үүнд ард иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, боловсролын чанарыг дээшлүүлэх, хүн амын өсөлт, дундаж наслалт, цар тахлын халдвар хамгаалал, урьдчилан сэргийлэх гэх мэт асуудалд бодлого боловсруулагчид түлхүү анхаарлаа хандуулжээ.

Нөгөө талаас Оросын аюулгүй байдлын бичиг баримтууд шинэчлэн батлагдсан он цагийг харьцуулан харвал тухайн үеийн олон улсын үйл явдал болон Оросын дотоодын нөхцөл байдалтай уялдаж байна.

Гурав. Үндэсний аюулгүй байдлыг хангах

Баримт бичигт тусгаснаар улсын үндэсний аюулгүй байдлыг үндэсний стратегийн тэргүүлэх чиглэлд заасан зорилгод хүрч, асуудлыг шийдвэрлэх замаар хангана хэмээн заасан⁶ бол хуучин стратегид үндэсний аюулгүй байдал нь үндэсний стратегийн тэргүүлэх чиглэл хийгээд ҮАБ-ыг хангах тогтолцооны үүргийн үр дүнгээс шууд хамаарна хэмээн заасан⁷ байна.

Батлан хамгаалах

Оросын хилийн дагуух НАТО-ийн цэргийн дэд бүтцийн байршил болон АНУ-ын пуужингаас хамгаалах цогцолбор зэрэг нь стратегийн тогтвортой

6 2021 онд батлагдсан ОХУ-ын ҮАБ стратеги, 27 дугаар зүйл хуудас 9

7 2015 онд батлагдсан ОХУ-ын ҮАБ стратеги, 33 дугаар зүйл хуудас 9

байдлыг алдагдуулж байна хэмээн үзэх шалтгаан болдог. Үүнтэй холбогдуулан 2015 оны Үндэсний аюулгүй байдлын стратеги батлагдсанаас хойших хугацаанд Оростой сөргөлдөгч талаас цэргийн аюул занал хийгээд зэвсэгт мөргөлдөөн ихсэх хандлагатай болсон талаар шинэ баримт бичигт тусгасан байна. Оросын батлан хамгаалах бодлогын зорилго нь ОХУ-ын нийгэм, эдийн засгийн хөгжлийг болон цэргийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх хэмээн заасан бөгөөд тус стратегийн үндэсний аюулгүй байдлыг хангах тухай IV бүлгийн батлан хамгаалах тухай дэд бүлэгт “дэлхийн цэрэг улс төрийн нөхцөл байдлыг “бүс нутгийн төдийгүй дэлхийн шинэ хүчний төвүүд бий болж тэдний хооронд нөлөөний бүсээ тогтоох тэмцэл хурцдаж байна. Улмаар олон улсын харилцааны субъектууд өөрийн геополитикийн зорилгодоо хүрэхийн тулд цэргийн хүчийг нэгэн арга хэрэглүүр хэмээж ач холбогдлыг ихэсгэж байна” хэмээн тодорхойлжээ. Ингэхдээ Хойд-Атлантын гэрээний байгууллагын цэргийн дэд бүтцээ Оросын хилийн ойролцоо хуримтлуулан тагнуулын үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ ихээхэн хэмжээний цөмийн зэвсгийн болон цэргийн хүч бий болгон ОХУ төдийгүй түүний түнш, холбоотон улсуудад хүчний дарамт шахалт үзүүлж байна хэмээн тусгасан байна.

Түүнээс гадна, хуучин Зөвлөлт лагерын орон зай төдийгүй Ойрх дорнод, Умард Африк, Афганистан болон Солонгосын хойгийн бүсэд маргаантай байдал үргэлжлэх хандлагатай байгаа талаар дурджээ.

Батлан хамгаалах бодлогыг иргэний хамгааллын хэрэглэгдэхүүн, хүчний бэлэн байдлыг дээшлүүлэх, ОХУ-ын Зэвсэгт хүчин болон улсын цэргийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох цэрэг дайны маргаанаас урьдчилан сэргийлэх болон стратегийн хязгаарлах арга замаар хэрэгжүүлнэ. Ингэхдээ, дараах зорилтуудад анхаарал хандуулж байна. Үүнд:

1. Дайны аюул занал болон цэрэг дайны одоо байгаа болон ойрын ирээдүйд болох магадлалтай аюулыг цаг алдалгүй илрүүлэх;
2. ОХУ дахь цэргийн тогтолцоог сайжруулах, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын бүрэн эрхт байдлыг хамгаалах, Оросод учирч болох хийгээд цэргийн хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэн улс төр, цэрэг, цэрэг техник, дипломат, эдийн засаг, мэдээлэл болон бусад арга хэмжээг уялдуулан авч хэрэгжүүлэх;
3. Цөмийн зэвсгийн хазаарлах чадамжийг зохих түвшинд дэмжих;
4. Цэргийн байгууллага, бүрэлдэхүүн, Зэвсэгт Хүчнийг байлдааны бэлэн байдалд зохих түвшинд хангах;
5. Гадаад улсад буй ОХУ-ын иргэний болон ОХУ-ын үндэсний ашиг сонирхлыг хамгаалах;
6. Цэргийн байгууллагын хэрэглэгдэхүүнийг тэнцвэртэй хөгжүүлэх, Зэвсэгт хүчин, батлан хамгаалах, цэргийн байгууллага, бүрэлдэхүүнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн болон тусгай техникээр хангах;
7. Улсын цэргийн байгууллагын цэрэг техникийн чадамжийг зохих түвшинд

8 ОХУ-ын ҮАБ-ын стратеги 34 дүгээр зүйл

- дэмжих, цаг тухай бүрд шинэчлэх, мөн ОХУ-д дайчилгаа, дайчилгааны бэлтгэл хангах төлөвлөгөөт арга хэмжээг сайжруулах;
8. Орчин үеийн зэвсэгт мөргөлдөөн, дайны шинж чанар, өөрчлөлт хандлагыг цаг тухай бүрд тооцоолох болон цэргийн хүчийг хэрэглэх нөхцлийг бий болгох зорилгоор зэвсэгт тэмцлийн шинэ зэвсэглэл болон бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг боловсруулах;
 9. ОХУ-ын батлан хамгаалахын үйлдвэрлэлийг технологийн хараат байдалгүй байлгах, цэргийн болон тусгай техник, шинэ зэвсэглэл үйлдвэрлэх, боловсруулах болон тус салбарт тэргүүлэгч байр суурийг хадгалах;
 10. Дайны цагт хүн амын хэрэгцээ, улсын хэрэгцээг хангах болон зэвсэгт халдлагаас хамгаалахад цэргийн бүрэлдэхүүн, бусад хүчин, Зэвсэгт хүчин, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны байгууллагын бэлэн байдал, орон нутгийн эдийн засаг, бүс нутгийн эдийн засаг, ОХУ-ын эдийн засгийн бэлтгэлийг хангах;
 11. ОХУ-ын газар нутагт зэвсэгт мөргөлдөөний үед болон зэвсэгт мөргөлдөөний үр дүнд үүсэж болохуйц биет болон соёлын үнэт зүйлийг хамгаалах, ард иргэдийг хамгаалах бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулах;
 12. Зэвсэгт Хүчин, бусад хүчин, цэргийн бүрэлдэхүүн болон байгууллагад цэргийн дэг журам, хууль журам мөрдүүлэх, бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн болон улс төр ёс зүйг дээд түвшинд дэмжих;
 13. Цэргийн албанд татах бэлтгэл болон цэрэг эх оронч хүмүүжил суулгах;
 14. Цэргийн алба хаагч, албанаас халагдсан болон тэдний гэр бүлийн нийгмийн хамгаалалын түвшинг дээшлүүлэх;

*Стратегийн тогтвортой байдал, олон улсын
хамтын ажиллагаа*

Оросын ҮАБ-ын стратегид олон улсын харилцаанд хэрэгжүүлэх бодлого чиглэлийг тодорхойлохдоо 2015 онд “Стратегийн тогтвортой байдал хийгээд ижил тэгш стратегийн түншлэл” хэмээж байсан бол шинэчлэн батлагдсан стратегид “Стратегийн тогтвортой байдал хийгээд харилцан ашигтай олон улсын хамтын ажиллагаа” хэмээн нэрлэснээс ерөнхий чиглэлийг харж болох юм. Доорх хүснэгтээр аюулгүй байдлын бодлогын баримт бичигт тусгасан анхаарал хандуулахуйц заалтуудыг харьцуулан харуулав.

Хүснэгт 3. Стратегийн тогтвортой байдлын тухай ҮАБС-д тусгагдсан нь

Стратегийн тогтвортой байдал хийгээд ижил тэгш стратегийн түншлэл (2015)	Стратегийн тогтвортой байдал хийгээд харилцан ашигтай олон улсын хамтын ажиллагаа (2021)
88. ОХУ нь БРИКС, ШХАБ, РИК, “Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа” чуулган, “Их 20-ын бүлэг” болон бусад механизмдын хүрэн дэх түншүүдтэйгээ хамтын ажиллагааг хөгжүүлэх	101-7. ОХУ нь ШХАБ, БРИКС механизмын хүрээнд олон талт хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, РИК (Орос, Энэтхэг, Хятад)-ийн хүрэн дэх хамтын ажиллагааны институтчилал болон функционал үндэс суурийг бэхжүүлэх
-	101-14. Гадаад улс дахь ОХУ-ын иргэн болон Оросын аж ахуй нэгжийн эрх хийгээд ашиг сонирхлыг хамгаалах
97. Европын холбооны улс орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх...	-
98. үй олноор хөнөөх зэвсэглэл дэлгэрүүлэхгүй, зэвсэглэл хязгаарлах гэрээ, бүс нутгийн мөргөлдөөнийг зохицуулах зэрэг олон улсын нөхцөл байдал төдийгүй эдийн засгийн харилцаа зэрэг ашиг сонирхол давхцаж буй салбарт АНУ-тай түншлэлийн харилцааг хөгжүүлэх	-
99. Арктикийн бүс нутагт ижил тэгш харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд онцгой анхаарах	101-17. Сансрын орон зай, далайн орон зай, Антарктик, Арктикийн бүс нутгийг эзэмшихтэй холбоотой ОХУ-ын ашиг сонирхлыг хангах
-	101-29. ОХУ-ын транзит тээврийн чадамжийг ашиглах, олон улсын тээврийн интеграцид нэгдэх

Эх сурвалж: 2015 болон 2021 оны ОХУ-ын ҮАБ-ын стратегиас боловсруулав

Дээрх харьцуулсан хүснэгтээс ЕХ-той хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, АНУ-тай түншлэлийн харилцаа тогтоохтой холбоотой заалтууд шинэ батлагдсан баримт бичигт хасагдсаныг харж болох бөгөөд Орос, Өрнөдийн орнуудтай харилцах харилцааны хямралыг харуулж байгаа бол “гадаад улс дахь ОХУ-ын иргэн болон аж ахуй нэгжийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах” гэсэн заалт нэмэгджээ.

Баримт бичигт уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс, соёл, түүхэн ой санамжийг хамгаалахад түлхүү анхаарал хандуулж байгаа нь сүүлийн жилүүдэд тус улсын удирдлагын баримталж буй бодлоготой нийцэж байна. Оросын зүгээс гадны орнуудын найрсаг бус үйлдлийн хариуд тэгш болон тэгш бус байдлаар хариу арга хэмжээ авахад бэлэн байгааг удаа дараа илэрхийлж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Мөн хуучин стратегид Оросын дотоод, гадаад бодлогод хөндлөнгөөс оролцох,

эдийн засгийн чадавхийг сулруулах зорилгоор АНУ тэргүүтэй өрнөдийн орнууд хориг шахалт үзүүлэн олон улсын харилцаанд Оросыг хазаарлаж давуу байдалтай оролцох оролдлогыг сөрөхөд чиглэсэн байв. Түүний хүрээнд Оросын зүгээс цэрэг арми, хүчний байгууллагын тусламжтайгаар улс орондоо өнгөт хувьсгал, террорист халдлага гаргахаас урьдчилан сэргийлж дотоодын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна. Харин шинэ стратегид олон улсын түвшинд шинэ дэг журам бүхий архитектур бий болж хүчний дахин хуваарилалт, шинэ бүтэц бий болж байгаатай холбоотойгоор геополитикийн тогтворгүй байдал, улс хоорондын мөргөлдөөн, үл ойлголцол ихсэж байна. Үүнтэй холбоотойгоор тэргүүлэх байр сууриа алдаж буй улс орнууд бусад орнуудад өөрийн шударга бус өрсөлдөөний дүрмийг тулгаж байна. Ингэхдээ хориг арга хэмжээ авах зэргээр бүрэн эрхт улс орнуудын дотоод хэрэгт шууд хөндлөнгөөс оролцож олон улсын эрх зүйн тогтсон хэм хэмжээг үгүй хийж цэрэг улс төрийн нөхцөл байдлыг хурцатгаж улс орнуудын харилцаанд итгэлцлийг сулруулж ойлгомжгүй байдлыг бий болгож байна хэмээн тусгажээ. Энэ нөхцөл байдалд Оросын гадаад бодлогыг тодорхойлохдоо, “Оросын Холбооны Улс нь олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх өөрийн улсын үндэсний ашиг сонирхлыг хамгаалах үүднээс нээлттэй, урьдчилан таамаглаж болохуйц, олон талт, хараат бус прагматик гадаад бодлогыг явуулж байна”⁹ хэмээн тодорхойлжээ.

Эдийн засгийн аюулгүй байдал

Өмнөх стратегид эдийн засгийн хөгжил тэр дундаа импортыг орлох дотоодын үйлдвэрийн талаар дурдаж байсан бол шинэ стратегид гадаад, дотоод нөлөөнөөс үл харгалзан эдийн засаг тогтвортой байдал буюу эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын чухлыг онцолсон байв. Үүнтэй холбоотойгоор гадаад худалдаандаа ам.долларын хэрэглээг багасгах, өндөр технологид суурилсан эдийн засаг хөгжүүлэх, нүүрс ус төрөгчийн эрчим хүч гаргаж авах зэрэг шинэлэг асуудал тусгажээ.

Мөн 2021 оны 7 дугаар сарын 16-ны өдөр болсон Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулганы үеэр Оросын ерөнхийлөгч В.Путин “цар тахлын дараах эдийн засгийн хямралыг намжаах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр энэ ондоо багтаад эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өсөх болно¹⁰” хэмээн мэдэгдэв. Түүний мэдэгдэл нь олон улсын судалгааны Fitch агентлагийн прогнозтой дөхүү буюу ДНБ-ийн өсөлт 3,7% байх төлөвтэй байна¹¹. Дээр дурдсан америк долларын хэрэглээг багасгахтай холбоотойгоор Орос, Хятадын зүгээс худалдааны тусгай бүтэц байгуулах талаар 2021 оны эцсээр хоёр улсын төрийн тэргүүн нарын түвшинд тохиролцоонд хүрсэн нь манай хоёр хөршийн харилцаа улас нягтарч буйг илтгэж байна.

9 Стратегия национальной безопасности “Стратегическая стабильность и взаимовыгодное международное сотрудничество”, п.96

10 Путин заявил о восстановлении экономики России <https://lenta.ru/news/2021/07/16/repair/>

11 Outlook 2021: Global economic outlook <https://www.fitchratings.com/campaigns/outlooks/global-economic>

Дүгнэлт

Оросын Холбооны Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг орлох болсон тус баримт бичгийг Холбооны хуулийн дагуу зургаан жилд нэг удаа улс орны дотоод гадаад нөхцөл байдлаас үүдэн шинэчлэн найруулж ерөнхийлөгчийн зарлигаар баталдаг байна.

Шинэчлэн батлагдсан “ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги” нь хүний хөгжил, ард иргэдээ хамгаалах асуудлыг тэргүүн зэрэгт тавьж, түүх соёлын дурсгал болон ард түмний уламжлалт оюуны өвийг хамгаалах тухай заалтыг шинээр оруулсан нь ойрын ирээдүйд үндэсний дархлаагаа хамгаалах болон орчин үеийн шинжлэх ухаан технологийн хөгжилд суурилсан эдийн засгийг хөгжүүлэхэд илүү анхаарах чиг хандлагыг илэрхийлж байгаагаараа онцлогтой байна. ОХУ стратегийн тогтоон барих бодлого, зорилтын хүрээнд зэвсэгт хүчнээ улам бэхжүүлж, өөрийн төдийгүй холбоотон, түнш орнуудынхаа аюулгүй байдлыг хамгаалах тухай асуудлыг уг баримт бичигт тусгасан нь олон улсын тавцанд хүчтэй тоглогч байх эрмэлзэл хэвээр байгааг харуулж байна. Мөн хил орчмын бүс нутагт энхтайван, тогтвортой байдлыг хадгалах зорилгоор хөрш орнуудад тогтворгүй байдлын голомт үүсэхээс урьдчилан сэргийлэх, үүссэн асуудлыг намжаах чиглэлээр хамтарч ажиллах тухай заалтуудыг оруулснаараа онцлог байна.